

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

Хүүхдийн чихний дэлбэнгийн арын судсыг шинжлэх судар бүтээсэн Монгол, Төвөд эрдэмтдийн цадиг түүх

Улаан-Од Х.¹, Шагдарсүрэн Д.², Болд Ш.³

¹“Ач” Анагаах ухааны их сургууль, ²Долмалин эмнэлэг,

³Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургууль

Abstract

Biography of Mongolian and Tibetan Scholars who Created Sutra about Ear Vein Reading

Ulaan-Od Kh.¹, Shagdarsuren D.², and Bold Sh.³

¹“Ach” Medical University, ²Dolmalin Hospital

³International School of Mongolian Medicine,
Mongolian National University of Medical Sciences

The “Oral Instruction Tantra” of the “Four Medical Tantras” divides diseases in children into 4 parts: causes, condition, categories, and symptoms. The diseases are proven with inquiries and examination by touching and looking. The most interesting type of examination is considered to be touching, which the main part is pulse-feeling. However, pulse feeling of children in traditional medicine is different from that of adults.

The general diagnostic method of traditional medicine consists of 3 parts: pulse reading, visual diagnosis (tongue and urine), hearing, and investigation. The diagnostic method of pediatrics in traditional medicine is based on the general method but different in some ways in consistence with the classification of diseases in children.

The following conclusions are being made from the study. The basis of a pediatrics in Mongolia established when Mongolians began to learn the “Four Medical Tantras” of Indian Ayurvedic medicine in Sanskrit.

Since then, Mongolian doctors and scientists have created many works based on the books of Indian and Tibetan medicine scholars. Among them, there are several books about method of ear vein reading written by Mongolian doctors and scholars.

This is confirmed by this study. In addition to our study, it is also important for biographies of people who have been involved in the creation of the traditional knowledge including traditional medicine.

Key words: Four Medical Tantras, biographies, ear vein reading

Pp. 108-112, Figures 3, References 8

Удиртгал

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-т Нялхсын өвчнийг шалтгаан, нөхцөл, ангилал, шинж тэмдэг хийгээд засах арга гэсэн 4 хэсэгт хуваан үзүүлдэг. Хүүхдийн өвчний шалтгаан нь хий, шар, бадган гурав юм. Нөхцлийг эхийн болон хүүгийн нөхцөл гэж 2 зүйлд хуваана. Эхийн нөхцөл нь эхийн идээ, явдал мөрийн аль нэг нь аривдсанаар хий, шар, бадганы бэлгэ чанар арвидан улмаар эхийн хий, шар, цус, бадганы алины язгуур хүүд унаж, ариун бус адын нөхцлөөр дүлий, хэлгий, тахир, бөгтөр, сохор, сэтэрхий уруултай зэрэг эмгэгтэй төрдөг. Эдгээр нь хамт төрсөн өвчин мөн тул анагааж чадахгүй хэмээжээ. Нөгөө

талаар хүүгийн нөхцөлд ад, явдал мөр, идээ гурав багтана. Адын нөхцөл олон ч нялхсын ад 12 байдаг. Явдал мөр гэдэгт эх болон хүүхдийн асрагч нар асаргаа сувилгааг зохистой хийгээгүйн улмаас хүүхэд унах, цохигдох, сэгсрэгдэх, хүйс татагдах, хэтэрхий уйлах, хэт их чийг авах, идээ ундааг хэт халуун эсвэл хэт сэрүүн шүтсэнээр нялхсын 24 язгуур өвчнийг үүсгэнэ [1]. Эдгээр өвчнийг асуух, хүрэлцэх, үзэх шинжилгээгээр нотолно хэмээжээ.

Хүрэлцэх шинжилгээний үндсэн арга нь судас барих арга юм. Уламжлалт анагаах ухааны тогтолцоонд хүүхдийн судсыг барих арга нь

насанд хүрэгсдийн судсыг барихаас өөр байдаг. 0-8 хүртэлх насны хүүхдийг шинжлэхдээ чихний дэлбэнгийн арын судсыг үзэх аргыг хэрэглэнэ. Гэхдээ энэ арга XX зууны эхэн үеэс сүүл үе хүртэл үндсэндээ мартагдах шахсан байна. Цаашид уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчин судлалын салбарыг сэргээн хөгжүүлэхдээ хүүхдийн өвчний оношзүй түүний дотор чихний дэлбэнгийн арын судсыг шинжлэх аргын үндсийг судлан тогтоох, ялангуяа эхэлж хийх ёстой ажлын нэг бол энэ чиглэлээр судар ном бичсэн эртний эмч, эрдэмтдийн бүтээлийг онцгойлон үзэж, эрэн сурвалжилж, нэгтгэн дүгнэх, тэдгээрийн цадиг түүхийг тодруулах нь нэн чухал юм.

Зорилго

Өнөөгийн мэдлэгийн хэрээр олдсон хүүхдийн чихний дэлбэнгийн арын судсыг шинжлэх чиглэлээр судар ном бичсэн Монгол, Төвөд эмч, эрдэмтдийн цадиг түүхийг тодруулах.

Судалгааны материал

Бид судалгаандаа Монголын нэг, Төвөдийн хоёр судлаач, эрдэмтдийн судар, бүтээлийг гол материал болгон ашиглав. Үүнд:

-Чойжамц. *གཞི་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་ཚིའི་སྒྲིང་པོ་ཚ་གཏང་*
ཟུག་རྩ་སེལ་བའི་དོ་མཚན་ *དགའ་སྟོན་གཏོར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*

Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

-Гонман Гончогдэлэг. *མཁས་པའི་མན་ངག་ཀུན་འདུས་དགོས་*
བ་ཀུན་འབྱུང་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Мэргэдийн увдис бүгдийг хураасан иж бүрэн шашдир хэмээх оршивай. 009, Бээжин, Ардын хэвлэлийн хороо, 2001

-Дэумар Данзанпунцаг. *དེའུ་དམར་གསོ་རིག་གཅེས་བཞུས།*
Улаан толгодын анагаах ухааны шимийн хураангуй. 044, Бээжин, Ардын хэвлэлийн хороо, 2001

Судалгаанд хэрэглэсэн аргууд

1. Нийгмийн судалгааны чанарын арга (Qualitative Methods in Social Research) [2]

Чанарын судалгааны цөм нь судлаач өөрөө бөгөөд өдрийн тэмдэглэл, захидал, сонин, сэтгүүл, ном, видео бичлэг, кино, фото зураг зэрэг мэдээллийн төрөл бүрийн туслах эх үүсвэрийг ашиглана. Чанарын судалгаанд үг, өгүүлбэр, бичвэр мэдээлэл, холбоо хамааралд тулгуурлан тухайн судалгааны эцэст таамаглал

дэвшүүлэх, хэн юу гэж өгүүлсэнд гол анхаарлаа хандуулдаг арга. Бид уг аргыг ашиглан хүүхдийн чихний дэлбэнгийн арын судсыг шинжлэх чиглэлээр судар ном бичсэн Монгол, Төвөд эмч, эрдэмтдийн талаар өгүүлсэн тэмдэглэл, сонин, сэтгүүл, ном, фото зургийн агуулгад буй тухайн зохиогчийн талаар юу гэж бичсэнийг илэрхийлэхээс илүүтэй яагаад ингэж бичив гэдэгт дүгнэлт өгөхөд уг аргыг ашиглав.

2. Эх бичиг судлалын арга

Уг судалгааны арга нь сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг, нэрийн хэлхээ зэргийг нэгэн дор хамтатган судлахад оршдог. Бид судалгаанд ашигласан сурвалж материалаа эрэмбэлэн дэс дараалалд оруулан судалгаа хийж улмаар бүтээлийн доторх агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг мэдээг тодруулан шүүн тунгааж үзэв.

Үр дүн

Бид судалгааныхаа явцад хүүхдийн чихний дэлбэнгийн арын судсаар оношлох нийт 6 эх сурвалж олж тогтоосон. Үүний 2 сурвалж нь өнгөрсөн зууны сүүлээр бичигдсэн харьцангуй шинэ бүтээлүүд байсан учраас уг бүтээлүүд чухам эртний ямар судар номуудад тулгуурлаж бичигдсэнийг эрэн сурвалжилж одоогоор 4 судар олж тогтоогоод байна. Эдгээр 4 судраас одоогийн Хөвсгөл аймгаас олдсон “Чихний судасны шинэ толь” судар [3] зохиогчгүй учраас энэ удаагийн судалгааны үр дүнд оруулсангүй. Харин үлдсэн 3 судрын нэгийг нь Их хүрээний эмчийн сургуулийн бурхан урлаач буюу бурханч лам, олон багш мэргэдийн өлмийн тоосыг орой зулайгаараа шүтсэн гэлэн Чойжамц бичсэн бөгөөд товчоор “Маш гайхамшигт баясгалангийн хуримын сан” [4] хэмээдэг. Үлдсэн 2 судар нь төвөд эрдэмтдийн эрт үед бичигдсэн бүтээл юм. Тухайлбал: Гонман Гончогдэлэг 1447 онд төрж, 1506 онд мөнх бусыг үзүүлсэн. Өнөөгийн байдлаар Гонман Гончогдэлэгийн хүүхдийг шинжлэх, хүүхдийн өвчнийг оношлох талаар бичсэн *ཕྱིས་པའི་ནད་གསོ་བ་དངོས།* “Хүүхдийн өвчнийг бодитой анагаах нь” (*རྫ་རྩ་ཐེག་བཞི།*) судар нэн эртнийх гэж үзэхээр байна. Дараагийн хүн нь Дэумар гэвш Данзанпунцаг юм. Тэрбээр 1672 онд [5] Төвөдийн Хам аймгийн Чамдо хэмээх газарт төрсөн. Түүний *དེའུ་དམར་གསོ་རིག་གཅེས་བཞུས།* “Улаан толгодын анагаах ухааны шимийн хураангуй” бүтээлийн дотор буй *ཕྱིས་པའི་རྫ་རྩ་བརྟག་བ་གསལ་སྒྲིང་གྲུ་མེ་ལོང་གཡའ་བྲལ།* “Хүүхдийн чихний дүрсийг шинжлэн тодруулагч гэрэл, дэлбэнгийн толь, буртагийг салгагч” гэсэн сонирхолтой бүтээл байна.

1. Бурхан урлаач Чойжамц



Их хүрээний эмчийн сургуулийн бурханч лам, олон багш мэргэдийн өлмийн тоосыг орой зулайгаараа шүтсэн гэлэн Чойжамц 1860-? оны хооронд амьдарч байсан бөгөөд уг нь бурхан бүтээдэг мэргэжилтэй боловч эмийн номонд гаргуун сайн байжээ. Тэрбээр *གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་ཚིའི་སྒྲིང་པོ་ཚ་གང་ཟུག་རྩ་ལེལ་བའི་ངོ་མཚར་དགའ་སྟོན་གཏིར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།* “Анагах ухааны олон чухал номуудаас хураасан рашаан шим, халуун, хүйтний эвэршээлийг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан”, товчоор “Маш гайхамшигт баясгалангийн хуримын сан” хэмээдэг 11□26 см, 206 хуудастай номыг Наран гэрэлт, түмэн наст Богд Жавзандамба хутагтыг (VIII Богд) хаан ширээнд өргөмжлөгдсөний 11 дүгээр он, XV машид гарсны төмөр тахиа жилийн (1921 он) зуны тэргүүн сарын шинийн найманд эхэлж, усан нохой жилийн (1922 он) намрын адаг сарын шинийн гурванд сүүлчийг хураан сайтар найруулсан байна.

Энэ бүтээлийн хүүхдийн өвчний бүлэгт хүүхдийн өвчнийг хэрхэн оношлох, хэрхэн эмчилж, засах талаар тодорхой дурдаад, 115 дугаар нүүрэн (а, б)-д хүүхдийн чихний дэлбэнгийн арын судсыг хэрхэн шинжлэх талаар тусгай зураг дагалдуулан үзүүлсэн байдаг.

2. Гонман Гончогдэлэг



གོང་སྐུན་དཀོན་མཚོག་བདེ་ལེགས། монголоор галигчлавал Гонман Гончогдэлэг хэмээнэ. *གོང་སྐུན་* гэдэг манай Зава Дамдин, Анги Шагдар, Лүнриг Дандар гэдэгтэй адил өргөмж нэр юм. “Үнэт эм” гэсэн утгатай.

Гонман Гончогдэлэг 1447 онд Төвөдийн өмнө зүгт, Шигац мужийн ойролцоо “Цагаан шороот” гэдэг газар төрж, 1506 онд мөнх бусыг үзүүлжээ. Тэрбээр бага наснаасаа бурхны шашны боловсрол олж авсан бөгөөд эрийн цээнд хүрэхийн үед Вранди Чойжалдаш болон Вранди Балгандорж нарын заавраар анагаах ухаанд суралцжээ. Вранди гэдэг нь 704 онд Төвөдийн хаан *འཇིག་ལུགས་བཟུང་* Тидээгзсан буюу Мээгцом хаан (680-743 оны хооронд амьдарч байсан, 704-755 оны хооронд Төвөдийн хаан байв)-ы ордонд байгуулагдсан ордны эмч нарын улаан бүлэгт багтсан эмч нарын алдар юм.

Гонман Гончогдэлэг бээр Вранди Чойжалдаш багшийн анагаах ухааны эрдмээс шимтэн суралцаж ихэд сайн боловсрон, хааны ордны эмч нарын улаан бүлэгт нэр нь алдаршиж эхэлжээ. Энэ талаар түүний намтарт “Сажагийн хоёр давхар асрын эмийн хотод сав төгөлдөр Гонман Гончогдэлэг хэмээх гарч Врандичойжалдашийг даган оршсоноор мэргэдийн хэргэмд хүрсэн бөгөөд тэргүүн эмч (оточ) хэмээн алдаршин, эмчийн ёсны оройн дээд нь болжээ” хэмээсэн байдаг.

Ийнхүү Гончогдэлэг Цаст уулын Төвөд оронд нэр цуугаа мандуулахын зэрэгцээ бүх анагаах ухааны номлолын дийлэнхид суралцсан бөгөөд Энэтхэг, Төвөдийн олонх мэргэдийн анагаах ухааны язгуур үндэс, нуусан эрдмийг ч хураан авч, улмаар өөрт болон бусдад туслахын төлөө олон арван судар номыг найруулан туурвижээ. Төвөд анагаах ухааны чиглэлээр бичсэн одоо мэдэгдээд байгаа нь 13 судар байна.

Тухайлбал:

1. Увдисын улаан боть;
2. Увдисын хар боть;
3. Увдисын олон өнгөт боть буюу Увдисын алаг боть;
4. Бэрх тайлбар орших бүгдийг тодруулсан зул;
5. Үндсийн цадиг түүх;
6. Эмийн нэрийн баримтлал;
7. Эмийн нэрийн зөв бичих дүрэм;
8. Дөрвөн үндсийн бэрх хэлхээсийг арилгагч шар хуйлмал;
9. Судас, шээсний тайлал, нүүрний увдисыг нээн гаргагч;

10. Өвсөн эмийн гарал үүслийн утгын хураангуй;
11. Амт, чадлыг холбон найруулах нь;
12. Их үндсийн сэтгэл татам бичээс улаан мод;
13. Хүүхдийн өвчнийг бодитой анагаах нь (ᠵᠢᠰᠡᠬᠡᠭᠢᠨᠠᠨᠠᠭᠠᠬᠤ) зэрэг зохиолууд буй.

Түүний бүтээлийн талаар Дэсрид Санжаажамцын “Төвөдийн анагаах ухааны түүх” номонд тодорхой тэмдэглэжээ [6].

Гонман Гончогдэлэг ལྷན་ཚེན་ཁྲ་མོ་བེ་བུམ་སེང་ལྗེ་ལ། (Их үндсийн сэтгэл татам бичээс улаан мод) бүтээл нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн дамжлага, сургалтад онцгой ач холбогдолтой, түүний утгыг машид дэлгэрүүлэн найруулж зохиосон гэдэг. Ялангуяа багшийг шүтэх хүн хэрэгтэйг харсан төдийгөөр зовлонг гэтлэх боломжтойг таалан зохиосноор анагаах ухаан, заслыг номлосон дээд нөхдийн сүсэг бишрэлийг ихэд агуулсан хэмээдэг.

Тэрбээр олон шавь дагалдуулан сургаснаас эрхэм шавь нь Гонман Гончогпандар хэмээн нэрд гарсан байдаг. Сонирхолтой нь Гонман Гончогдэлэг нь Гончогпандарын нагац ах нь байжээ.

Түүний бүтээлүүдийг མཁའ་པའི་མན་ངག་གུན་འདུས་དགོས་པ་གུན་འབྱུང་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Мэргэдийн увдис бүгдийг хураасан иж бүрэн шашдир хэмээх оршивай. Товчлоод གསོ་རིག་དགོས་པ་གུན་འབྱུང་། (gso rig dgos pa kun 'byung) гэдэг нэрийн дор 2001 онд хэвлэсэн бөгөөд англи хэлээр “An Exhaustive Treatise on Medicine” харин монгол хэлээр “Анагаах ухааны иж бүрэн шашдир” хэмээдэг [7]. Энэ зохиол дотор ལྷན་ཚེན་ཁྲ་མོ་བེ་བུམ་སེང་། “Хүүхдийн өвчнийг бодитой анагаах нь” (ᠵᠢᠰᠡᠬᠡᠭᠢᠨᠠᠨᠠᠭᠠᠬᠤ) гэсэн судар буй. Уг судрын эхний хэсэгт чихийг хэрхэн шинжлэх талаар, дараагийн хэсэгт судасны шинжийн талаар бичсэнээс гадна эмчилгээний аргыг нь нэмж өгсний зэрэгцээ чихний судасны дөрвөн тийгин зургийн тайлбарыг дагуулсан байдаг.

3. Дэүмар Данзанпунцаг



བཟུན་འཛིན་ལུན་ཚེགས།
Данзанпунцаг

Дэүмар гэвш Данзанпунцаг нь 11 дүгээр жарны усан хулгана жил буюу 1672 онд Төвөдийн Хам аймгийн Чамдо буюу өнөөгийн БНХАУ-ын ТӨЗО-ны Зүүн хэсэгт орших, мужийн түвшингийн Чанду хотод төржээ. Эцгийг нь Дорждаш, эхийг нь Лхага гэдэг бөгөөд Вижиг овогтон байв. Вижиг нь анагаах ухааны урт хугацааны уламжлалтай овог юм.

Дэүмар гэж нэрлэсний учир нь Зүүн Төвөдийн Алтанбаясгалант хэмээх тосгоны өмнө талд орших уулын “Улаан толгой”-н хажууд олон жил амьдарсан тул Улаан толгойн Данзанпунцаг буюу Дэүмар Данзанпунцаг гэсэн алдрыг олжээ. Тэрбээр 5 наснаасаа суурь боловсролоо эзэмшиж эхлээд, хожим нь анагаах ухааны чиглэлээр суралцаж эхэлжээ. Тухайлбал འཛིན་གྲར་ Зигар хийдэд Гарма Данпэл болон Агваангунгааданзан (1680-1728 он) багшийн дор гаажуд буюу аман дамжлага (“Oral Lineage” or Whispered Transmission school)-ын сургуульд суралцжээ. Ялангуяа анагаах ухаан, зурхайн ухаанд шамдаж эхэлсэн байна.

Данзанпунцаг Зигар хийдэд ажиллаж байхдаа зарим нэг лам нартай тодорхой бус шалтгаанаар зөрчилдөж, уг зөрчил нь шийдвэрлэгдэх боломжгүй болсны эцэст Дэргэ, Гонжо, Нанчэн болон Чамдогийн хооронд байрлах Лхатог хотыг орхин явжээ.

Лхатог хотод байхад нь орон нутгийн захирагч Лхатог Жалболодой түүний академик бүтээлүүдийг хамарсан дөчин хоёр ботийг сүйтгэж, заримыг гол руу шидэж, заримыг нь шатаасан байна. Амь нас, амьдрал нь хутганы ирэн дээр ирсэнийг мэдсэн Данзанпунцаг шууд зугтан гарч улмаар Хятадын Юнань мужаар дамжин Энэтхэгт мөргөл үйлдэхээр оджээ.

Энэтхэгээс Төвдөд буцаж ирсний дараа Дэүмар гэвш Данзанпунцаг ихэнхдээ Лхас хотоос холгүй орших Сэратэгчэнлин болон Намцо хийдүүдэд амьдарч байсан мэдээ бий. Мөн зарим үед Дэргэ хотын Гончэн хийдэд очиж ном бүтээл туурвих ажлаа хийдэг байв. Ялангуяа Саллам Бадмаванжал, Вижилам Даш, Радо Лхасобадмаван нарын хүсэлтээр Төвөдийн урлаг, гар урлалын бүтээлийн гарын авлагыг бичжээ. Түүний академик бүтээлүүд нь зуун гарсан бөгөөд Буддын шашин, санскрит хэл, төвөд хэл, зурхай, анагаах ухаан, урлаг зэргийг хамардаг. Тэрбээр дорно дахины анагаах ухааны дотроос эмийн түүхий эд, дан эмийн нэршил, ангилал, эмчилгээний заалтыг судлах талаарх дорвитой бүтээлүүд турвисан байдаг. Тухайлбал “Шилэн бөмбөг”, “Шилэн эрх” хэмээх эмийн түүхий эдийн бүтээл нь өнөө ч

гэсэн уламжлалт анагаах ухааныг сурч, судалж байгаа хүмүүсийн чухал гарын авлага болсоор байна. Үүнээс гадна Төвөдийн үйлдвэрлэл, түүх, ёс заншиллын талаарх бүтээлүүд нь Төвөдийн уран зургийн орчин үеийн судалгаанд ч чухал ач холбогдолтой хэвээрээ байна.

Дэүмар гэвш Данзанпунцагийн *དེུ་དམར་གསོ་རིག་གཞུང་བུས།* “Улаан толгодын анагаах ухааны шимийн хураангуй” номын дотор *བྱིས་པའི་རྩ་བ་བརྟག་བ་གསལ་སྣང་ག་* *ཡི་མེ་ལོང་གཡའ་བལ།* “Хүүхдийн чихний дүрсийг шинжлэн тодруулагч гэрэл, дэлбэнгийн толь, буртагийг салгагч” [8] гэсэн бэсрэг бүтээл буй. Уг номонд нярайлснаас хойш 12 хоногоос 8 нас хүртэл чихний мөгөөрс (чихний дэлбэнгийн арын судас)-өөр дэлбэнгийн толийг тодруулваас гэмийг сайтар таслах бөгөөд онохын тулд анхлан зөн буулгах

Ном зүй

1. *བདུད་རྩི་སྤོང་པོ་ཡན་ལག་བརྒྱུད་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྒྱུད་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ།*
Модон барын төвөд судар
2. Social Science Collection Guides: Topical Bibliographies. Qualitative Methods in Social Research. www.bl.uk/reshelp/findhelpsubject/socsci/topbib/methsocial. Хандалт хийсэн 2018.08.15
3. Чихний судасны шинэ толь. Гар бичмэл, төвөд судар
4. **Чойжамц.** *གསོ་རིག་གཞུང་མང་བཟུས་པའི་བདུད་རྩི་སྤོང་པོ་ཚ་གང་རྩག་*
རྩ་སེལ་བའི་ *ངོ་མཚར་དགའ་སྟོན་གཏོར་མཚོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།* Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.
5. **Жамбапринлай** *གངས་ཚོངས་གསོ་རིག་བཟུན་པའི་ཉིན་བྱེད་རིམ་བྱོན་*
ཀྱི་རྣམ་ཐར་ཚུགས་བསྐྱེགས། *མི་རིགས་དཔེ་སྟུན་ཁང་།*, 1990.

адистидыг эрхэмлэх хэрэгтэй гэсэн байдаг.

Судалгааны ажлын үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Монголд хүүхдийн өвчин судлалын үндэс нь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны “Дөрвөн үндэс”-ийг санскрит хэлээр үзэж эхэлсэн тэр үеэс тавигдсан гэж үзэх үндэстэй юм. Үүнээс хойш Монгол эмч, эрдэмтэд Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн ном сударт суурилан олон арван бүтээл туурвижээ. Эдгээрийн дотор хүүхдийг чихний дэлбэнгийн арын судсаар шинжлэх хүүхдийн өвчнийг оношлох цөөнгүй бүтээл бичжээ. Энэ нь ч дээрх судалгаагаар батлагдаж байна. Түүнчлэн уламжлаж ирсэн мэдлэгийг судлахын тулд бүтээлээс гадна түүнийг зохиосон хүмүүсийн намтар чухал болох нь бидний судалгаанаас харагдаж байна.

6. **Дэсрид Санжаажамц.** *དཔལ་ལྷན་གསོ་བ་རིག་པའི་ལོག་འབྲུག་*
ས་ལགས་བཤད་བེད་རྩེ་མེ་ལོང་དྲང་སྲོང་དགུས་པའི་དགའ་སྟོན་བཞུགས་སོ།
Модон барын төвөд судар
7. **Гонман Гончогдэлэг.** *མཁས་པའི་མན་ངག་ཀུན་འདུས་དགོས་*
བ་ཀུན་འབྱུང་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Мэргэдийн увдис бүгдийг хураасан иж бүрэн шашдир хэмээх оршивай. 009, Бээжин, Ардын хэвлэлийн хороо, 2001
8. **Дэүмар гэвш Данзанпунцаг.** *དེུ་དམར་གསོ་རིག་གཞུང་བུས།* “Улаан толгодын анагаах ухааны шимийн хураангуй”. 044, Бээжин, Ардын хэвлэлийн хороо, 2001

Танилцаж, нийтлэх санал өгсөн:

Анагаах ухааны доктор, профессор
Д.Цэрэндагва